

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 55 дугаар зүйлийн 55.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Сангийн сайдын 2023 оны А/262 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Ерөнхий гэрээний аргаар бараа, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг” (цаашид “жишиг баримт бичиг” гэх)-д доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/ 1 дүгээр бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 15 дугаар зүйлд 15.11 дэх заалт:

“15.11.Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр бараа санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.”

2/ 4 дүгээр бүлгийн тендер илгээх 1 дүгээр маягтад 9 дэх заалт:

“9.Ерөнхий гэрээ байгуулж, цахим дэлгүүрт бүртгэгдсэн тохиолдолд цахимаар үнэ дуудах ажиллагаанд оролцохыг зөвшөөрч байна.”

3/ 5 дугаар бүлгийн гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйлд 5.1.7 дахь заалт:

“5.1.7.гэрээний хүчинтэй байх хугацаанд гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээ цуцлагдсан, эсхүл сунгагдаагүй бол.”

4/ 5 дугаар бүлгийн гэрээний ерөнхий нөхцөлийн 6 дугаар зүйлд 6.22 дахь заалт:

“6.22.Гэрээний хүчинтэй байх хугацаанд гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дуусгавар болох нөхцөл бий болсон бол хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө энэ талаар мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, гэрээний үүргийг тусгай зөвшөөрөл, гэрчилгээний хугацаа сунгасан шийдвэр гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэрийг мэргэжлийн байгууллага гаргаж болно.”

2.Жишиг баримт бичгийн 4 дүгээр бүлгийн нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтын 6 дугаар маягтын “үндэслэл” гэсний дараа “, тайлбар” гэж, 5 дугаар бүлгийн гэрээний ерөнхий нөхцөлийн 2.12 дахь заалтын “ГТН-д” гэсний дараа “өөрөөр” гэж тус тус нэмсүгэй.

3.Жишиг баримт бичгийн 2 дугаар бүлгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.1 дэх заалтын “бичих.” гэсний дараах хашилт доторх өгүүлбэрийг ““Тийм” гэж хариулсан бол санхүүгийн чадавхтай холбоотойгоор хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож шаардаж болох ба бусад баримт бичиг шаардахыг хуулиар

зөвшөөрөөгүй болохыг анхаарна уу.” гэж, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1 дэх “бичих.]” гэсний дараах хашилт доторх өгүүлбэрийг ““Тийм” гэж хариулсан бол техникийн чадавх, туршлагатай холбоотойгоор хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан болон 17.4-т хамаарах баримт бичгээс сонгож шаардаж болох ба бусад баримт бичиг шаардахыг хуулиар зөвшөөрөөгүй болохыг анхаарна уу. -Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэж бичих. Хэрэв шаардах бол оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг IV бүлгийн Маягт 4-ийн дагуу ирүүлнэ.” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

4.Жишиг баримт бичгийн 4 дүгээр бүлгийн тендер илгээх 1 дүгээр маягтын 5 дахь заалтын хашилт доторх “30 ба түүнээс дээш хоногийн тоо” гэснийг “ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо” гэж, мөн заалтын “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, тендер шалгаруулалтын зарлалын 6 дахь заалтын “30 ба түүнээс дээш хоногийн]” гэснийг “ажлын 30 ба түүнээс дээш] өдрийн” гэж тус тус өөрчилсүгэй.

5.Энэ тушаалыг холбогдох журмын дагуу бүртгүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Ганбат), Хууль, эрх зүйн газар (З.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Б.ЖАВХЛАН